



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 08 сарын 31 өдөр

Дугаар 6/520

Улаанбаатар хот

Ш.Галбадрахад сахилгын  
шийтгэл ногдуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5, 8.4 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 27 дугаар зүйлийн 27.4.3, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1, 37.1.8, 37.1.13, 48 дугаар зүйлийн 48.1.2 дахь заалт, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7 дахь заалт, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 36/32 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журам"-ын 3.5.2, 4.1 дэх хэсэг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2021 оны А/705 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Улсын бүртгэлийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-ын 10.1, 10.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:


1.Нийслэлийн Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн төрийн үйчилгээний Дүнжингарав нэгдсэн төв дэх Улсын бүртгэлийн тасгийн иргэний улсын бүртгэгч Шатарбалын Галбадрах нь хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй, эрхэлсэн ажилдаа хайнга хандсан болох нь хяналтын улсын байцаагчийн 2022 оны 5110 дугаартай дүгнэлтээр тогтоогдсон тул 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2.Өдөр тутмын үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомжийг мөрдөж, албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийг хэрэгжүүлж, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандахыг улсын бүртгэгч Ш.Галбадрахад үүрэг болгосугай.

3.Албан хаагчдад ажлын хариуцлага, дэг журмыг чанд сахин ажиллахыг анхааруулж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газар /Г.Анхныбаяр/, Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс /П.Мөнхбаатар/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Г.Цолмон/-т үүрэг болгосугай.

4.Энэ тушаалыг эс зөвшөөрвөл тушаалыг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор төрийн албаны төв байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА



Д.ДЭЛГЭРСАЙХАН

112203704